

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Соёл Урлагийн Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Аудитын код: САГ-2019/104/СТА-ТӨҮГ

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай компани
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан .....	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин.....	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
	2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
	2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
	2.11. Шилэн дансны мэдээлэл .....	9
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал .....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
	4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
	4.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан.....	14
	4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
	4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
	4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
5	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	22



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.03.20 № 06/540  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Соёл урлагийн их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Соёл урлагийн их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Соёл урлагийн их сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Соёл урлагийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сургуулийн захирал Э.Сонинтогос Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Соёл урлагийн их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Соёл урлагийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 15-наас 2019 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Төгс нягт гурав аудит” ХХК-ийн захирал Д.Цэнд хянан удирдаж, чанарын хяналтын менежер З.Тунгалаг, аудитор Д.Эрдэнэтуяа, Д.Батсүх, аудиторовын туслах С.Баярсайхан нар хариуцаж хэрэгжүүлэв.

Соёл урлагийн их сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 01/93 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Соёл урлагийн их сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Соёл урлагийн их сургууль соёл урлагийн мэргэжлээр авьяаслаг бүтээлч, шилдэг уран бүтээлч, мэргэжилтнийг бэлтгэж, төрөөс соёл урлагийн талаар баримтлах бодлогод дэмжлэг үзүүлэхүйц судалгааны ажлыг явуулдаг монгол үндэсний соёл урлагийн гол уурхай болно гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллаж байна.

Тус байгууллага дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Бакалавр, магистр, докторын сургалт, ахлах сургууль, гүнзгийрүүлсэн болон нарийн мэргэжлийн бэлтгэл, мөн мэргэжил дээшлүүлэх сургалтыг явуулах;
- Соёл урлагийн чиглэлээр улсын хэмжээний салбарын урт, богино хугацааны хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох, зөвлөгөө өгөх;
- Зорилтот суурь болон хэрэглээний судалгаа хийх, шинэ мэдлэг бүтээж сургалт, судалгааны эргэлтэд оруулах, бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Гэрээт, захиалгат, төлөвлөгөөт сэдэв, асуудлаар судалгаа, уран бүтээл, туршилт зохион бүтээлтийн ажлыг гүйцэтгэж, инновацыг нэвтрүүлэх, гарааны компани, инкубатор байгуулах үйл ажиллагаа эрхлэх;
- Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн сургалт, судалгааны хөтөлбөр модулиудыг боловсруулан хэрэгжүүлэх, гадаад харилцаа, улс хоорондын хамтын ажиллагаа хөгжүүлэх;
- Үндэсний болон олон улсын хэмжээний консорциум, холбоо, нэгдэл, парк, кластерт нэгдэн орох;
- Оюуны өмчийг баталгаажуулах, эзэмших, патент-лицензийн үйл ажиллагаа эрхлэх;
- Зөвлөх үйлчилгээ, уран бүтээл зуучлалын үйлчилгээ эрхлэх;
- СУИС-ийн үйл ажиллагааг сурталчлах, үндэсний болон олон улсын хэмжээний наадам, үзэсгэлэн, форум, тэмцээн, соёл урлагийн үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах.



Соёл урлагийн их сургууль нь Радио телевиз, медиа урлагийн сургууль, Дүрслэх дизайн урлагийн сургууль, Соёлын сургууль, Хөгжмийн урлагийн сургууль, Театрын урлагийн сургууль, Бүжгийн урлагийн сургууль гэсэн бүтцийн 6 сургууль болон Төв сургууль, Бадмаараг лицей сургууль, Соёл урлаг судлалын хүрээлэн, Гадаад хэлний институт гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Дээрх байгууллагуудын тайлан нэгтгэгдэж Нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргасан.

Соёл урлагийн их сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

2018 оны жилийн эцсийн тайлангаар нийт орлогын 86,8 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу оюутны сургалтын төлбөрийн орлого эзэлж байна.

Туслах үйл ажиллагааны орлого оюутны дотуур байрнаас орох орлого, хүүгийн орлого, төсөл хөтөлбөрийн орлого, дадлагын орлого, оюутан театрын орлого зэргээс бүрддэг.

Соёл урлагийн их сургуулийн удирдлага төсвийн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Дээд боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус сургуулийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2017 онд шинэчлэгдсэн бөгөөд тайлант хугацаанд Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжуудын өөрчлөлтийг тухай бүр нь тусган мөрдөж байна.

Соёл урлагийн их сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцаад мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Соёл урлагийн их сургууль нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous”, санхүүгийн тайлангийн нэгтгэлийн Plastic, цалингийн Payroll программ хангамж ашигладаг байна.

Соёл урлагийн их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтыг хангалттай хэрэгжүүлсэн байна.

Үндсэн орон тооны 1 аудитортой /тайлант онд дотоод аудиторын мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан/ касс, харилцахын хуулга, гүйлгээ, шилэн дансны хөтлөлтийг хяналтанд авсан, гадаад, дотоод томилолтын гүйцэтгэл, үр дүн, өмнөх аудитын зөвлөмжийг биелүүлэн ажилласан байна.

Удирдах зөвлөл, захирлын удирдамж өгсөн ажлыг нь төлөвлөгөөний дагуу тухай бүр гүйцэтгэж, тайлан бичиж хугацаатай үүрэг, зөвлөмж өгч гүйцэтгэлийг нь тооцож ажилласан байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Соёл урлагийн их сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 11 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгосон нь зардлыг голчлон авч үздэгтэй холбоотой юм.

Соёл урлагийн их сургуулийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 10,680.5 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 106.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 10 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.



Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая.төг)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж	2	81.0	
2	Акт	1	2.1	
Нийт дүн			83.1	

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд тус сургуулийн захирлын 2018 оны Б/155 тоот тушаалаар өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 789,030.00 /долоон зуун наян есөн мянга гуч/ төгрөгийн тэтгэмж олгосон байна.

2. 2018 оны 9 дүгээр сард 1,335,000.00 /нэг сая гурван зуун гучин таван мянга/ төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар цэцэг худалдан авсан байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байгаа тул улсын төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлэв.

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Соёл урлагийн их сургуулийн захирал Э.Сонинтогос, Бүх Холбоотын төрийн санхүүжилттэй байгууллага болох “Оросын Холбооны Улсын номын сан”-гийн Мэдээлэлжүүлэлт хариуцсан дэд захирал Груздев Игорь Александрович нарын 2017 оны 11 дүгээр сарын 17-нд байгуулсан Оросын Холбооны Улсын номын сангийн Диссертацийн цахим номын санг ашиглах 095/04/0219 тоот гэрээний үр дүнг жил бүрийн аудитаар нарийвчлан шалгаж байх нь зүйтэй байна.

### 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Соёл урлагийн их сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан тус сургуулийн Удирдах зөвлөлөөр 2018 онд 13,060.5 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Үндсэн үйл ажиллагааны батлагдсан орлого 9,078.6 сая төгрөг, гүйцэтгэлээр 7,912.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж 87.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Энэ нь улсын төсвөөс авах тогтмол зардлын санхүүжилт 240.5 сая төгрөгөөр, сургалтын төлбөрөөс төвлөрүүлэх орлого 395.0 сая төгрөгөөр дутуу байгаа нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн нийт зарлага 10,498.7 сая төгрөг буюу 80.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: Цалингийн зардлыг 1,134.4 сая төгрөг буюу 15.2 хувиар, Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 134.4 сая төгрөг буюу 15.0 хувиар, хөрөнгийн зардлыг 158.8 сая төгрөг буюу 33.2 хувиар тус тус хэмнэсэн нь зардлын хэмнэлтэд голлон нөлөөлжээ.

Төсвийн зарлагын гүйцэтгэл 80,4 хувьтай байгаа нь төлөвлөлтийн үндэслэлийг нягтлах нь зүйтэй гэж үзэж байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Соёл урлагийн их сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

1. Тайлант хугацаанд Үндэсний аудитын газраас “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг шалгасан бөгөөд тус шалгалтаар зөрчил илрээгүй байна.
2. Тус сургуулийн дотоод аудит тогтмол хяналт тавьдаг
3. Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны аудитаар 1 төлбөрийн акт тогтоож, хөрөнгө, өглөг, авлага, орлого, зардалтай холбоотой 7 зөвлөмж өгсөн бөгөөд актын төлбөрийг бүрэн барагдуулж, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Бид Соёл урлагийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Соёл урлагийн их сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Соёл урлагийн их сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурьдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. Илрүүлэлт

1.1 Тайланд онд төслөөр 199.2 сая төгрөгийн 24 ажлын гүйцэтгэлтэйгээс 2 ажлын гүйцэтгэл дутуу хийгдсэн байна. Үүнд:

1.“Соёл судлалын тэнхимийн судалгааны ажлыг эрчимжүүлэх” судалгааны ажил чиглэл өөрчлөгдсөн шалтгаанаар 30 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.“Оросын Холбооны Улсын номын сангийн Диссертацийн цахим номын сан”-г оюутнууд ашиглах төслийн ажил одоогоор үргэлжлэн явагдаж байна.

1.2 Эрсдэл

Төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулаагүйгээс ажлын гүйцэтгэл дутуу хийгдэх; Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх

1.3 Зөвлөмж

- Тайлант онд хийгдэх төслийн ажлыг бизнес төлөвлөгөөнд нэр төрлөөр нь удирдах зөвлөлөөр батлуулж хэвших;
- Цаашид бүрэн хэрэгжүүлэх боломжтой хөтөлбөр арга хэмжээг бодитой төлөвлөх;

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Дээрх зөвлөмжийг хүлээн зөвшөөрч, асуудлын бүртгэлийг гарын үсэг зурж баталгаажуулсан. Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 07 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхээр тогтов.

## 2. Илрүүлэлт

2.1 Тайлант онд хийгдсэн 78.0 сая төгрөгийн засварын ажлын зурган баримтууд огноогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

### 2.2 Эрсдэл

Тайлан буруу илэрхийлэгдэх болон баталгаажихгүй байх

### 2.3 Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах;

### 2.4 Төсвийн захирагчийн хариу

Дээрх зөрчлийг удирдлага, санхүүгийн ажилтанд асуудлын бүртгэлээр танилцуулж баталгаажуулсан болно.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 07 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>7,694,340,560.28</u></b>	<b><u>7,433,110,695.18</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	5,234,553,744.46	4,611,817,399.14
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	3,768,775.33	3,778,154.83
31110	Төгрөг	3,768,775.33	3,778,154.83
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	5,230,784,969.13	4,608,039,244.31
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	3,873,894,697.15	3,788,453,188.29
31213	Арилжааны банк дахь харилцах	3,873,894,697.15	3,788,453,188.29
<b>3122</b>	<b>Гадаад валют</b>	1,356,890,271.98	819,586,056.02
31223	Арилжааны банк дахь харилцах	1,356,890,271.98	819,586,056.02
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,194,957,611.57	1,449,879,281.95
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	313,698.30	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,080,398,826.82	1,190,164,370.62
33300	Татаас, санхүүжилтийн авлага	76,681,113.07	223,543,739.15
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	36,231,473.38	35,638,672.19
3351	Байгууллагаас авах авлага	23,989,687.44	33,462,072.30
3352	Хувь хүмүүсээс авах авлага	12,241,785.94	2,176,599.89
<b>336</b>	<b>Зээлийн авлага</b>	1,332,500.00	532,500.00
<b>3361</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	1,332,500.00	532,500.00
33613	Сургалтын төрийн сангийн зээлийн авлага	1,332,500.00	532,500.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	00.00	11,563,540.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	11,563,540.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,264,829,204.25	1,359,850,474.09
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	146,635,367.52	145,978,300.00
35110	Тусгай зориулалттай материал	146,635,367.52	145,978,300.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	1,118,193,836.73	1,213,872,174.09
35410	Бичиг хэргийн материал	29,282,375.36	21,012,999.43
35420	Аж ахуйн материал	417,558,437.56	392,165,313.99
35430	Сэлбэг хэрэгсэл	10,717,842.50	5,816,494.00
35440	Түлш, шатах тослох материал	440,000.00	-
35450	Барилгын засварын материал	1,800,770.00	7,654,900.00
35470	Бусад хангамжийн материал	658,394,411.31	787,222,466.67
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>6,605,340,903.88</u></b>	<b><u>11,827,874,712.02</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	6,605,340,903.88	11,827,874,712.02
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	6,605,223,570.92	11,124,079,712.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,420,212,031.15	8,770,839,416.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5,201,201,874.97	-5,924,563.38
39203	Авто-тээврийн хэрэгсэл	238,088,000.00	256,638,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-184,046,333.23	-187,137,305.62
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,240,312,857.36	3,384,960,359.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2,344,160,798.31	-2,570,375,717.10

**Соёл Урлагийн Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,272,945,279.25	1,310,856,859.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-586,457,462.72	-645,832,771.52
39209	Зам, гүүрийн байгууламж	58,153,198.00	83,996,531.08
39210	Хуримтлагдсан элэгдэл	-46,311,959.08	-7,408,168.58
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,718,900.00	2,718,900.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	892,036,353.94	878,567,249.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	-712,800,997.71	-750,940,958.86
39216	Дуусаагүй барилга, байгууламж	50,947,426.00	19,673,314.00
39217	Ном	504,788,951.24	583,448,568.44
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	117,332.96	703,795,000.00
39301	Програм хангамж	10,007,000.00	8,140,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-9,889,667.04	-8,140,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	703,795,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>14,299,681,464.16</u></b>	<b><u>19,260,985,407.20</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>2,105,013,048.05</u></b>	<b><u>2,044,392,628.33</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,105,013,048.05	2,044,392,628.33
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,025,399,323.05	1,960,886,858.33
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,419,473.32	874,215.94
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	2,022,979,849.73	1,960,012,642.39
41361	Байгууллагад төлөх өглөг	67,835,135.61	8,619,067.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,955,144,714.12	1,951,393,575.39
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	79,613,725.00	83,505,770.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	79,613,725.00	83,505,770.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>12,194,668,416.11</u></b>	<b><u>17,216,592,778.87</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	12,194,668,416.11	17,216,592,778.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,209,405,270.44	4,872,800,270.44
51101	Өмч: - төрийн	4,209,405,270.44	4,872,800,270.44
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	7,056,740,739.34	6,714,267,097.11
51210	Өмнөх үеийн үр дүн	6,865,892,450.59	7,070,922,804.46
51220	Тайлант үеийн үр дүн	190,848,288.75	-356,655,707.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	928,522,406.33	5,629,525,411.32
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>14,299,681,464.16</u></b>	<b><u>19,260,985,407.20</u></b>



#### 4.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>10,337,388,018.09</b>	<b>10,185,165,222.94</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,337,388,018.09</b>	<b>10,185,165,222.94</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	10,337,388,018.09	10,185,165,222.94
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,606,552,825.54	9,173,543,334.86
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,263,870,861.81	8,053,315,219.33
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,065,689,433.73	980,257,022.53
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	276,992,530.00	139,971,093.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>730,835,192.55</b>	<b>1,011,621,888.08</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	616,835,192.55	884,830,888.08
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	204,537,433.35	236,862,626.08
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	412,297,759.20	647,968,262.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	114,000,000.00	126,791,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	114,000,000.00	126,791,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>10,110,924,070.87</b>	<b>10,599,386,677.29</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>10,110,924,070.87</b>	<b>10,599,386,677.29</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	10,008,945,950.87	10,485,390,848.29
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	5,954,886,999.53	6,397,585,222.17
210101	Үндсэн цалин	5,622,715,654.28	6,044,251,459.31
210105	Гэрээт ажлын хөлс	332,171,345.25	353,333,762.86
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	649,183,380.11	763,228,588.44
210201	Тэтгэврийн даатгал	427,327,070.49	525,672,329.32
210202	Тэтгэмжийн даатгал	55,155,052.10	63,411,219.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	53,821,117.34	54,097,684.46
210204	Ажилгүйдлийн даатгал	9,314,657.91	9,884,754.81
210205	Эрүүл мэндийн даатгал	103,565,482.27	110,162,600.41
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	204,863,087.35	237,002,325.08
210301	Гэрэл, цахилгаан	89,972,061.39	111,018,900.30
210302	Түлш, халаалт	84,105,623.83	83,347,539.06
210303	Цэвэр, бохир ус	30,785,402.13	42,635,885.72
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	307,857,517.52	412,913,242.54
210401	Бичиг хэрэг	51,498,971.61	47,259,490.66
210402	Тээвэр, шатахуун	29,946,751.00	32,821,996.95
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	67,399,335.08	72,072,724.42
210404	Ном, хэвлэл	70,437,537.88	82,807,267.96
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	70,405,489.90	116,740,803.46
210408	Бараа материал акталсны зардал	18,169,432.05	61,210,959.09

**Соёл Урлагийн Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	416,261,004.00	399,361,270.11
210604	Урсгал засвар	416,261,004.00	399,361,270.11
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	269,497,149.10	267,481,949.26
210701	Гадаад албан томилолт	213,846,663.96	202,594,333.22
210702	Дотоод албан томилолт	19,394,384.44	11,979,013.50
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	36,256,100.70	52,908,602.54
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	115,893,250.73	166,456,434.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	115,893,250.73	166,456,434.29
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,090,503,562.53	1,841,361,816.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	749,394,214.08	774,530,822.55
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	416,405,165.11	325,845,633.27
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	924,704,183.34	740,985,360.59
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	101,978,120.00	113,995,829.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	101,978,120.00	113,995,829.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	101,978,120.00	113,995,829.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>226,463,947.22</u></b>	<b><u>-414,221,454.35</u></b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	37,768,831.63	138,671,810.96
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	37,768,831.63	104,823,560.96
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз		33,848,250.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	73,384,490.10	81,106,063.96
225002	Найдваргүй авлагын алдагдал		8,095,994.50
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	73,384,490.10	45,347,160.40
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		27,662,909.06
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-35,615,658.46	57,565,747.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>190,848,288.75</u></b>	<b><u>-356,655,707.35</u></b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>10,589,667,604.12</b>	<b>9,778,562,147.28</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>9,811,826,224.12</b>	<b>8,913,002,885.28</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	9,811,826,224.12	8,913,002,885.28
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	9,811,826,224.12	8,913,002,885.28
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,673,554,184.29	7,912,761,097.04
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,138,272,039.83	1,000,241,788.24
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>777,841,380.00</b>	<b>865,559,262.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	663,841,380.00	738,768,262.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	115,000,000.00	90,000,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	548,841,380.00	648,768,262.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	114,000,000.00	126,791,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	114,000,000.00	126,791,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>9,382,654,066.77</b>	<b>9,951,095,922.74</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,382,654,066.77</b>	<b>9,951,095,922.74</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>9,265,932,096.77</b>	<b>9,835,850,852.14</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	5,780,437,036.17	6,318,591,455.49
210101	Үндсэн цалин	5,423,580,632.65	6,019,376,015.68
210105	Гэрээт ажлын хөлс	356,856,403.52	299,215,439.81
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	647,820,919.08	759,427,811.15
210201	Тэтгэврийн даатгал	426,440,573.88	524,923,517.98
210202	Тэтгэмжийн даатгал	54,890,773.80	63,364,007.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	53,248,709.76	52,430,782.48
210204	Ажилгүйдлийн даатгал	9,808,816.40	9,868,551.78
210205	Эрүүл мэндийн даатгал	103,432,045.24	108,840,951.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	204,863,087.35	237,002,325.08
210301	Гэрэл, цахилгаан	89,972,061.39	108,295,287.20
210302	Түлш, халаалт	84,105,623.83	86,071,152.16
210303	Цэвэр, бохир ус	30,785,402.13	42,635,885.72
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	468,377,883.01	446,054,033.24
210401	Бичиг хэрэг	47,913,917.00	47,915,980.92
210402	Тээвэр, шатахуун	28,826,694.00	32,472,234.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	67,892,435.08	73,029,064.42
210404	Ном, хэвлэл	184,562,418.43	168,945,131.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	139,182,418.50	123,691,622.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	435,772,679.00	479,081,133.90
210604	Урсгал засвар	435,772,679.00	479,081,133.90

Соёл Урлагийн Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	265,053,267.53	279,708,868.09
210701	Гадаад албан томилолт	212,268,039.36	221,150,353.39
210702	Дотоод албан томилолт	19,205,384.44	10,616,416.50
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	33,579,843.73	47,942,098.20
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	119,499,316.33	165,216,832.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	119,499,316.33	165,216,832.33
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,344,107,908.31	1,150,768,392.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	907,066,016.53	767,436,600.31
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	437,041,891.78	383,331,792.55
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>116,721,970.00</b>	<b>115,245,070.60</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	116,721,970.00	115,245,070.60
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	116,721,970.00	115,245,070.60
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>1,207,013,537.35</u></b>	<b><u>-172,533,775.46</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>-512,472,617.32</u></b>	<b><u>-547,604,884.70</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>512,472,617.32</b>	<b>547,604,884.70</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>512,472,617.32</b>	<b>547,604,884.70</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	512,472,617.32	547,604,884.70
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	512,472,617.32	547,604,884.70
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-512,472,617.32</u></b>	<b><u>-547,604,884.70</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>-33,688,589.45</u></b>	<b><u>97,402,314.84</u></b>
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	33,688,589.45	-97,402,314.84
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	33,688,589.45	-97,402,314.84
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>-33,688,589.45</u></b>	<b><u>97,402,314.84</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	660,852,330.58	-622,736,345.32
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	4,573,701,413.87	5,234,553,744.46
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	5,234,553,744.46	4,611,817,399.14

#### 4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан  
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2017 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	4,209,405,270.44	928,522,406.33	6,865,892,450.59	12,003,820,127.36
C07	Тайлант үеийн үр дүн			190,848,288.75	190,848,288.75
C08	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>4,209,405,270.44</b>	<b>928,522,406.33</b>	<b>7,056,740,739.34</b>	12,194,668,416.11
D01	<b>2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>4,209,405,270.44</b>	<b>928,522,406.33</b>	<b>7,056,740,739.34</b>	12,194,668,416.11
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>4,209,405,270.44</b>	<b>928,522,406.33</b>	<b>7,056,740,739.34</b>	12,194,668,416.11
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		4,701,003,004.99	14,182,065.12	4,715,185,070.11
D08	Тайлант үеийн үр дүн	663,395,000.00		-356,655,707.35	306,739,292.65
D09	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>4,872,800,270.44</b>	<b>5,629,525,411.32</b>	<b>6,714,267,097.11</b>	<b>17,216,592,778.87</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		5,234,553,744.46		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,060,527,049.89	10,498,700,807.44	2,561,826,242.45	80.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,581,764,749.89	10,178,689,852.94	2,403,074,896.95	80.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,429,486,884.89	10,063,444,782.34	2,366,042,102.55	81.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,453,004,169.08	6,318,591,455.49	1,134,412,713.59	84.8
210101	Үндсэн цалин	6,881,448,319.88	6,019,376,015.68	862,072,304.20	87.5
210105	Гэрээт ажлын хөлс	571,555,849.20	299,215,439.81	272,340,409.39	52.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	893,796,470.56	759,427,811.15	134,368,659.41	85.0
210201	Тэтгэврийн даатгал	600,134,904.70	524,923,517.98	75,211,386.72	87.5
210202	Тэтгэмжийн даатгал	76,575,256.76	63,364,007.16	13,211,249.60	82.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	59,843,153.60	52,430,782.48	7,412,371.12	87.6
210204	Ажилгүйдлийн даатгал	13,590,059.58	9,868,551.78	3,721,507.80	72.6
210205	Эрүүл мэндийн даатгал	143,653,095.92	108,840,951.75	34,812,144.17	75.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	327,451,305.03	237,002,325.08	90,448,979.95	72.4
210301	Гэрэл, цахилгаан	130,439,072.88	108,295,287.20	22,143,785.68	83.0
210302	Түлш, халаалт	124,213,588.10	86,071,152.16	38,142,435.94	69.3
210303	Цэвэр, бохир ус	72,798,644.05	42,635,885.72	30,162,758.33	58.6
2104	Хангамж, бараа материалын зардал	570,096,089.86	446,054,033.24	124,042,056.62	78.2
210401	Бичиг хэрэг	65,109,510.00	47,915,980.92	17,193,529.08	73.6
210402	Тээвэр, шатахуун	40,906,852.00	32,472,234.00	8,434,618.00	79.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	86,992,520.00	73,029,064.42	13,963,455.58	83.9
210404	Ном, хэвлэл	225,629,160.00	168,945,131.90	56,684,028.10	74.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	73,215,741.86	54,276,829.00	18,938,912.86	74.1
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	78,242,306.00	69,414,793.00	8,827,513.00	88.7



**Соёл Урлагийн Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	792,694,299.00	706,675,064.10	86,019,234.90	89.1
210602	Тавилга	304,144,699.00	223,881,227.20	80,263,471.80	73.6
210604	Урсгал засвар	488,549,600.00	482,793,836.90	5,755,763.10	98.8
2107	Томилолт, зочны зардал	390,105,250.00	279,708,868.09	110,396,381.91	71.7
210701	Гадаад албан томилолт	290,931,890.00	221,150,353.39	69,781,536.61	76.0
210702	Дотоод албан томилолт	35,888,400.00	10,616,416.50	25,271,983.50	29.6
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	63,284,960.00	47,942,098.20	15,342,861.80	75.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	176,254,831.36	165,216,832.33	11,037,999.03	93.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	176,254,831.36	165,216,832.33	11,037,999.03	93.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,826,084,470.00	1,150,768,392.86	675,316,077.14	63.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,139,882,740.00	767,436,600.31	372,446,139.69	67.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	686,201,730.00	383,331,792.55	302,869,937.45	55.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	152,277,865.00	115,245,070.60	37,032,794.40	75.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	152,277,865.00	115,245,070.60	37,032,794.40	75.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	152,277,865.00	115,245,070.60	37,032,794.40	75.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	478,762,300.00	320,010,954.50	158,751,345.50	66.8
2200	Дотоод эх үүсвэрээр	478,762,300.00	320,010,954.50	158,751,345.50	66.8
222001	Тоног төхөөрөмж	228,362,300.00	179,912,940.50	48,449,359.50	78.8
223001	Бусад хөрөнгө	250,400,000.00	140,098,014.00	110,301,986.00	55.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,060,527,049.89	9,778,562,147.28	3,281,964,902.61	74.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	363,063,305.05	738,768,262.00	(375,704,956.95)	203.5
131001	Улсын төсвөөс санхүүжих	330,451,305.05	90,000,000.00	240,451,305.05	27.2
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	32,612,000.00	648,768,262.00	(616,156,262.00)	176.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	128,000,000.00	126,791,000.00	1,209,000.00	99.1
132001	Орон нутгийн төсвөөс	128,000,000.00	126,791,000.00	1,209,000.00	99.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	12,569,463,744.84	8,913,002,885.28	3,656,460,859.56	70.9

Соёл Урлагийн Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,078,644,903.91	7,912,761,097.04	1,165,883,806.87	87.2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	937,903,196.65	1,000,241,788.24	(62,338,591.59)	106.6
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,552,915,644.28		2,552,915,644.28	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		5,234,553,744.46		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,611,817,399.14		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО		1	-	
610001	Төрийн өмчит үйлдвэрийн газар		1	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	690	689	1	
620001	Удирдах ажилтан	18	18	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	441	425	16	
620003	Үйлчлэх ажилтан	69	70	(1)	
620004	Гэрээт ажилтан	162	176	(14)	

## 5 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын хураангуй тайлангийн хавсралт

### Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b>	<b>2018.12.31</b>	<b>Аудитын нэр:</b>	<b>Соёл урлагийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит</b>	<b>Аудитын код:</b>	<b>САГ-2019/104/СТА-ТӨҮГ</b>
---------------	-------------------	---------------------	---	---------------------	------------------------------

<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	<b>Соёл Урлагийн Их Сургууль</b>	<b>Сая.төг</b>
-------------------------------------	----------------------------------	----------------

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн хүнд 0,8 сая төгрөгийн тэтгэмж олгосон, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 1,3 сая төгрөгийн цэцэг авч зарцуулсан.	2.1	акт	Захирал	Э.Сонинтогос
				Санхүү, эдийн засгийн газрын дарга	Ж.Жагармаа
2	Засварын ажлын зурган баримтууд огноогүй	78.0	Зөвлөмж	Захирал	Э.Сонинтогос
				Санхүү, эдийн засгийн газрын дарга	Ж.Жагармаа
3	Тайлант онд төслөөр 199.2 сая төгрөгийн 24 ажил хийгдсэний 2 ажил гүйцэтгэл дутуу хийгдсэн байна.	3.0	Зөвлөмж	Захирал	Э.Сонинтогос
				Санхүү, эдийн засгийн газрын дарга	Ж.Жагармаа
	<b>Дүн</b>	<b>83.1</b>			